



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/405

Арвайхээр

Г Бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар Г  
шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын Онцгой комиссын 2020 оны 29 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын 2020 оны 29 дүгээр тэмдэглэлээр гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/384 дүгээр захирамжийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдаалах зохицуулалтыг хүчингүй болгож, хэвийн горимд шилжүүлж, хуучин цагийн хуваариар ажиллуулж, эрүүл ахуй, аюулгүй байдлыг чанд баримтлан, мөрдөж ажиллахыг чиглэл болгосугай.


3. Соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ, худалдаа үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж, хязгаарлалтын дэглэмийн хугацаанд төрийн байгууллага, улсын болон орон нутгийн өмчит байгууллага, бусад аж ахуйн нэгж, иргэдээс нийтийг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахад эрүүл ахуй, аюулгүй байдлыг чанд баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

4. Сургуулийн өмнөх болон бүх шатны боловсролын байгууллагууд, сургалтын төвүүдийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цартахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Амны хаалтаа зүүцгээе" аяныг эрчимжүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Онцгой байдлын газар (орлогч дарга, дэд хурандаа Б.Батбилэг), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100911